



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/6/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар

Утас: 70373089 Цахим хаяг: Batmyagmarg@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2026 он

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт



ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА С.ДЭЛГЭРЖАРГАЛ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.13 № 40

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн УТХО болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон 327,998.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 30.3 хувиар өссөн байна.

Бусад асуудал

4520050043

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилтын 83 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.06 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4		
33	АВЛАГА	5	512,768.81	263,549.48
34	УРЬДЧИЛГАА			
35	БАРАА МАТЕРИАЛ	6	184,613,096.00	469,425,476.60
351	Түүхий эд материал		140,000.00	140,000.00
3513	Эм боох материал		140,000.00	140,000.00
354	Хангамжийн материал		168,510,596.00	451,205,476.60
3541	Бичиг хэргийн материал		69,004,040.00	82,317,380.00
3542	Аж ахуйн материал		17,590,600.00	4,970,300.00
3543	Сэлбэг хэрэгсэл			3,640,000.00
3544	Түлш, шатах тослох материал			8,230,000.00
3547	Бусад хангамжийн материал		81,915,956.00	352,047,796.60
356	Мал амьтад		15,962,500.00	18,080,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		10,969,600.00	19,234,600.00
363	Тэжээлийн нөөц		10,969,600.00	19,234,600.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		196,095,464.81	488,923,626.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,511,739,332.51	1,624,554,229.21
392	Биет хөрөнгө		1,354,839,892.55	1,469,437,649.29
39201	Барилга, байгууламж, орон сууц		391,798,183.00	512,786,721.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(62,175,709.57)	(78,815,773.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		158,494,800.00	156,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(2,494,800.00)	(31,200,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		425,280,477.64	617,153,987.88
39206	Хуримтлагдсан элэгдэл		(85,555,820.01)	(86,596,539.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		26,747,339.84	27,801,099.84
39208	Хуримтлагдсан элэгдэл		(15,765,299.81)	(6,443,759.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө		642,360,238.60	519,710,592.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(123,849,517.14)	(161,858,677.86)
393	Биет бус хөрөнгө		156,899,439.96	155,116,579.92
39301	Програм хангамж		8,914,300.00	8,914,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(2,820,860.04)	(4,603,720.08)
39303	Бусад биет бус хөрөнгө		150,806,000.00	150,806,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,511,739,332.51	1,624,554,229.21
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,707,834,797.32	2,113,477,855.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10		
51	Засгийн газрын хувь оролцоо		1,707,834,797.32	2,113,477,855.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		766,239,733.02	766,239,733.02
51101	Өмч: - төрийн		766,239,733.02	766,239,733.02
512	Хуримтлагдсан үр дүн		663,529,315.97	1,069,172,373.94
5121	Өмнөх үеийн үр дүн		663,529,315.97	663,529,315.97
5122	Тайлант үеийн үр дүн			405,643,057.97
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		278,065,748.33	278,065,748.33
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,707,834,797.32	2,113,477,855.29
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,707,834,797.32	2,113,477,855.29



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод-руулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,436,063,750.00	1,461,421,843.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,626,950.00	16,862,043.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж			5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,626,950.00	11,862,043.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,434,436,800.00	1,444,559,800.72
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,434,436,800.00	1,444,559,800.72
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих			
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		801,937,400.31	835,053,079.12
120	Нийтлэг татварын бус орлого		801,937,400.31	835,053,079.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,508,172.00	1,798,160.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,001,272.00	1,798,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,506,900.00	
120009	Бусад орлого		479,925.00	280,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		747,980,121.31	519,848,998.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		47,969,182.00	313,125,920.60
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	2,238,001,150.31	2,296,474,922.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,517,663,274.42	1,649,758,073.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,199,572,504.51	1,628,558,073.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		716,043,733.68	934,065,602.45
210101	Үндсэн цалин		390,757,008.89	440,898,741.72
210102	Нэмэгдэл		267,960,839.31	415,253,522.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт		16,674,838.33	16,498,950.92
210104	Урамшуулал		40,651,047.15	61,414,387.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		90,067,322.27	114,716,206.58
210201	Тэтгэврийн даатгал		63,156,399.99	81,169,946.02
210202	Тэтгэмжийн даатгал		7,415,975.50	9,755,062.99
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,662,873.00	4,679,815.21
210204	Ажилгүйдлийн даатгал		3,171,837.90	3,822,276.48
210205	Эрүүл мэндийн даатгал		12,660,235.88	15,289,105.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		41,661,830.89	50,398,680.02




III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	720,337,875.89	646,716,848.97
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,968,884.93	241,073,791.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,345,750.96	140,503,392.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	2,423,133.97	98,775,399.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	200,000.00	1,795,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,968,884.93)	(241,073,791.00)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	713,368,990.96	405,643,057.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,450,780,447.00	1,660,783,403.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,716,697.00	1,798,160.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,716,697.00	1,798,160.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,236,772.00	1,798,160.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,001,272.00	1,798,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,235,500.00	
120009	Бусад орлого	479,925.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,436,063,750.00	1,658,985,243.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,626,950.00	16,862,043.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,626,950.00	11,862,043.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,434,436,800.00	1,642,123,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,434,436,800.00	1,642,123,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,443,540,847.00	1,628,433,403.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,443,540,847.00	1,628,433,403.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,125,450,077.09	1,409,670,003.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,556,502.49	933,816,383.12
210101	Үндсэн цалин	391,269,777.70	440,649,522.39
210102	Нэмэгдэл	267,960,839.31	415,253,522.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,674,838.33	16,498,950.92
210104	Урамшуулал	40,651,047.15	61,414,387.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,067,322.27	114,716,206.58
210201	Тэтгэврийн даатгал	63,156,399.99	81,169,946.02
210202	Тэтгэмжийн даатгал	7,415,975.50	9,755,062.99



210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,873.00	4,679,815.21
210204	Ажилгүйдлийн даатгал	3,171,837.90	3,822,276.48
210205	Эрүүл мэндийн даатгал	12,660,235.88	15,289,105.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,661,830.89	50,398,680.02
210301	Гэрэл, цахилгаан	7,693,185.89	9,733,392.02
210302	Түлш, халаалт	33,968,645.00	39,420,288.00
210303	Цэвэр, бохир ус		1,245,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,576,076.00	26,089,112.00
210401	Бичиг хэрэг	3,672,000.00	3,980,350.00
210402	Тээвэр, шатахуун	16,259,276.00	15,841,762.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,223,100.00	4,623,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,286,700.00	1,643,100.00
2105	Нормативт зардал	1,050,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,710,250.00	70,623,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,679,000.00	
210604	Урсгал засвар	56,031,250.00	70,623,450.00
2107	Томилолт, зочны зардал	9,476,000.00	6,605,000.00
210702	Дотоод албан томилолт	9,476,000.00	6,605,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,563,175.44	94,875,512.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,660,839.44	94,025,242.00
210803	Даатгалын үйлчилгээ	226,090.00	171,720.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,500.00	223,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	89,000.00
210807	Газрын төлбөр	633,746.00	365,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,788,920.00	112,545,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,134,920.00	111,974,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,654,000.00	571,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	318,090,769.91	218,763,399.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,501,663.00	21,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,350,000.00	12,925,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,081,663.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,070,000.00	8,275,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	282,589,106.91	197,563,399.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	282,589,106.91	197,563,399.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,239,600.00	32,350,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,239,600.00	32,350,000.00
	Дотоод эх үүсвэрээр	7,239,600.00	32,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,239,600.00	32,350,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,239,600.00)	(32,350,000.00)

8

Ажил үйлчилгээний төлбөр, хураамж

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт

Төвлөрүүлэх шилжүүлэг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)

Дотоод эх үүсвэрээр

Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	620,239,733.02	278,065,748.33	(49,839,674.99)	848,465,806.36
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	146,000,000.00			146,000,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			713,368,990.96	713,368,990.96
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	766,239,733.02	278,065,748.33	663,529,315.97	1,707,834,797.32
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
17	Тайлант үеийн үр дүн			405,643,057.97	405,643,057.97
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	766,239,733.02	278,065,748.33	1,069,172,373.94	2,113,477,855.29



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,616,299,400.00	1,444,559,800.72	171,739,599.28	89.4
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,616,299,400.00	1,444,559,800.72	171,739,599.28	89.4
132001	Орон нутгийн төсвөөс	1,616,299,400.00	1,444,559,800.72	171,739,599.28	89.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		1,798,160.00	(1,798,160.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,798,160.00	(1,798,160.00)	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,616,299,400.00	1,446,357,960.72	169,941,439.28	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,616,299,400.00	1,414,007,960.72	202,291,439.28	87.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,636,400.00	1,392,807,960.72	197,828,439.28	87.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	952,967,700.00	933,816,383.12	19,151,316.88	98.0
210101	Үндсэн цалин	454,828,300.00	440,649,522.39	14,178,777.61	96.9
210102	Нэмэгдэл	418,415,000.00	415,253,522.64	3,161,477.36	99.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,214,300.00	16,498,950.92	715,349.08	95.8
210104	Урамшуулал	62,510,100.00	61,414,387.17	1,095,712.83	98.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,120,700.00	114,716,206.58	4,404,493.42	96.3
210201	Тэтгэврийн даатгал	81,002,200.00	81,169,946.02	(167,746.02)	100.2
210202	Тэтгэмжийн даатгал	9,529,700.00	9,755,062.99	(225,362.99)	102.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,764,700.00	4,679,815.21	84,884.79	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,764,700.00	3,822,276.48	942,423.52	80.2
210205	Эрүүл мэндийн даатгал	19,059,400.00	15,289,105.88	3,770,294.12	80.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,574,900.00	50,398,680.02	21,176,219.98	70.4
210301	Гэрэл, цахилгаан	14,192,800.00	9,733,392.02	4,459,407.98	68.6
210302	Түлш, халаалт	54,989,000.00	39,420,288.00	15,568,712.00	71.7
210303	Цэвэр, бохир ус	2,393,100.00	1,245,000.00	1,148,100.00	52.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,749,100.00	20,241,850.00	9,507,250.00	68.0
210401	Бичиг хэрэг	4,650,000.00	3,980,350.00	669,650.00	85.6
210402	Тээвэр, шатахуун	14,698,000.00	9,994,500.00	4,703,500.00	68.0



210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,138,500.00	4,623,900.00	514,600.00	90.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00		360,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,902,600.00	1,643,100.00	3,259,500.00	33.5
2105	Нормативт зардал	1,072,400.00		1,072,400.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,072,400.00		1,072,400.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,085,400.00	70,623,450.00	33,461,950.00	67.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,425,000.00		32,425,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	945,000.00		945,000.00	
210604	Урсгал засвар	70,715,400.00	70,623,450.00	91,950.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	14,666,900.00	6,605,000.00	8,061,900.00	45.0
210702	Дотоод албан томилолт	14,666,900.00	6,605,000.00	8,061,900.00	45.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,512,800.00	93,510,731.00	12,002,069.00	88.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,685,900.00	92,660,461.00	9,025,439.00	91.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,750,500.00		1,750,500.00	
210803	Даатгалын үйлчилгээ	294,000.00	171,720.00	122,280.00	58.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,000.00	223,800.00	21,200.00	91.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00		88,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,080,000.00	89,000.00	991,000.00	8.2
210807	Газрын төлбөр	369,400.00	365,750.00	3,650.00	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,886,500.00	102,895,660.00	88,990,840.00	53.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	190,686,500.00	102,324,660.00	88,361,840.00	53.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	571,000.00	629,000.00	47.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,663,000.00	21,200,000.00	4,463,000.00	82.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,663,000.00	21,200,000.00	4,463,000.00	82.6



213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,950,000.00	12,925,000.00	2,025,000.00	86.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,713,000.00	8,275,000.00	2,438,000.00	77.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		32,350,000.00	(32,350,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		32,350,000.00	(32,350,000.00)	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		32,350,000.00	(32,350,000.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,616,299,400.00	1,446,357,960.72	169,941,439.28	89.5
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31.00	24.00	7.00	77.4
6	Удирдах ажилтан	5.00	5.00		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	20.00	14.00	6.00	70.0
8	Үйлчлэх ажилтан	3.00	3.00		100.0
9	Гэрээт ажилтан	3.00	2.00	1.00	66.7
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31.00	24.00	7.00	77.4
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15.00	9.00	6.00	60.0
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00		100.0
34	Гэрээт ажилтан	3.00	2.00	1.00	66.7
35	Улс төрийн албан хаагч (УТ)	4.00	4.00		100.0



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16.862.043.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16.862.043.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16.862.043.00
2104	Хангамжийн бараа материалын зардал	5,847,262.00
210402	Тээвэр шатахуун	5,847,262.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,364,781.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,364,781.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	
2132	Бусад урсгал шилжүүлэг	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,862,043.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,862,043.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,862,043.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон сумын ЗДТГ нь "Нийтийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, хариуцлагатай хүргэж, шууд ардчиллын зарчмыг баримталсан, мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны тунгалаг байгууллага болох" эрхэм зорилгын хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн захиргааны удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг Дархан-Уул аймгийн Засаг даргын харьяаны байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хууль*
- *Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсан*
- *Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчлэн баталсан*

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтын талаар олж авсан ойлголтод үндэслэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнээр, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 405,943.0 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд гарсан материаллаг хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	512.7	263.5	(249.2)
Бараа материал	184,613.1	469,425.5	284,812.4
Үндсэн хөрөнгө	1,511,739.3	1,624,854.2	113,114.9
Нийт хөрөнгө	1,707,834.8	2,113,777.8	405,943.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,707,834.8	2,113,777.8	405,943.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,707,834.8	2,113,777.8	405,943.0

Авлагын эхний үлдэгдэлд бүртгэлтэй 4 албан хаагчаас авах 512.7 мянган төгрөгийн авлагаас 2 албан хаагчийн 249.2 мянган төгрөгийг цалингаас суутгаж, хүүхэд харах чөлөөтэй 2 албан хаагчаас авах 263.5 мянган төгрөгийн авлага жилийн эцэст үлдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 284,812.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 141,510.6 мянган төгрөгийн материал худалдан авсан, ЗДТГ-ын даргын 2025 оны 02-Б/15 тушаалаар 27,901.6 мянган төгрөгийн бараа материалыг акталсан, 133,657.6 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулсан зэргээс шалтгаалжээ. Бараа материалын үлдэгдэлд бусад хангамжийн материал 72.0 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны өсөлтөд 21,995.9 сая төгрөгийн ариун цэврийн байгууламж, өөрийн хөрөнгөөр 32,350.00 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер, МЗХНН Улаанбаатар төмөр замаас 56,069.9 мянган төгрөгийн 126 мкв барилга, Баян-Өлзийт баг болон Цагдаагийн хэсгийн байрыг дулаантай холбох 7,724.7 мянган төгрөгийн дулааны шугам, албан хаагчдын хийсэн 448,0 мянган төгрөгийн шүүгээ, "Анто-од" ХХК-наас нийгмийн хариуцлагын хүрээнд 9,900.0 мянган төгрөгийн мотор, 21,150.6 мянган төгрөгийн 3х3 талбай, УТХО-аар бичил үйлдвэр, үйлчилгээ дэмжиг зорилгоор 297,000.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн гүн хөлдөөгч, аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/571, 01-А/398 тоот захирамжаар төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслийн хүрээнд 5,1 сая төгрөгийн зөөврийн компьютер, Шинэ хөдөө төслийн хүрээнд олгогдсон 25,850.0 мянган төгрөгийн мал үржлийн тоног төхөөрөмж, аймгийн ИТХ-ын 2025 оны 06 тоот тогтоолоор 35,200.0 мянган төгрөгийн хуучин цэвэрлэх байгууламж, ОНӨГ-ын даргын тушаалаар ашиглалтын хугацаа сунгаж 42,296.2 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орлого авч, аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/05 тоот захирамжаар 68,899.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тайлант онд 200,105.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд биет бус хөрөнгөд 7,614.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй архив, санхүү, цахим бүртгэл программ бүртгэлтэй, тайлант онд программ хөгжүүлэлттэй холбоотой гарсан зардал байхгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,624,449.4 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн шууд захирагч 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,624,449.4 мянган төгрөгөөр тооцож төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг хянаж, 111,274.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,735,723.9 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг дутуу тооцооллыг нэмж, төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг хагас бүтэн жилээр 50 хувиар тооцсоныг 100 хувиар тооцон цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 32,467.7 мянган төгрөг, урсгал засварт 21,000.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 52,209.2 мянган төгрөг, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардал 72,130.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баяр наадмын зардал, эд хогшлын зардал, дотоод албан томилолт ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллаас хасаж баталсантай холбоотой байна. Тайлант онд орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор 119,424.5 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж 1,616,299.4 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,642,123.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,798.2 мянган төгрөгийн орлого олж, нийт 1,643,921.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Урсгал үйл ажиллагаанд 1,446,358.0 мянган төгрөг зарцуулж, санхүүжилтийн үлдэгдэл болон төвлөрсөн өөрийн орлогоос нийт 197,563.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,446,358.0 мянган төгрөг буюу 94.9 хувьтай гарсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,616,299.4	1,446,358.0	169,941.4	89.5
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	951,341.4	915,133.9	36,207.5	96.2
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	56,305.9	49,824.1	6,481.8	88.4
3	80102- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	153,576.4	146,502.7	7,073.7	95.4
4	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал,	142,290.3	121,022.1	21,268.2	85.0
5	80205-мэдээлэл сурталчилгааны зардал,	4,500.0	2,250.0	2,250.0	50
6	80233- хүүхэд хамгаалал	15,000.0	13,719.1	1,280.9	91.4
7	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	25,663.0	21,200.0	4,463.0	82.6
8	81102-орон нутгийн нөөц хөрөнгө	53,000.0	39,689.2	13,310.8	74.8

9	81518- мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх,	116,439.5	44,440.0	71,999.5	38.1
10	81549- Ахмадын сан,	5,997.0	5,915.0	82.0	98.6
11	81569- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх,	82,185.9	76,691.4	5,494.5	93.3
12	82801- Улсын их баяр наадам	10,000.0	9,970.5	29,5	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

"Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага" хөтөлбөрийн хүрээнд авсан санхүүжилтээр Орхон сумын .. иргэдэд эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, спорт, хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд зарцуулсан байна.

Нэгдсэн судалгааны дүнгээр Орхон сумын ЗДТГ-ын даргын 2023 оны Б/66 тоот тушаалаар байгууллагын албан хаагчид өдөрт олгох унааны хөнгөлөлтийг 2.1 мянган төгрөгөөр, хоолны хөнгөлөлтийг 1.0 мянган төгрөгөөр тогтоож, тайлант жилд төлөвлөсөн 16,198.0 мянган төгрөгийг 100 хувь зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас санхүүжүүлсэн өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой 10,000.0 мянган төгрөг, ойн хээрийн түймрийн эрсдэлтэй холбоотой эргүүлийн хийх шатахууны зардал 300.0 мянган төгрөг, мал тооллогын зардалд 1,562.0 мянган төгрөг, хуулийн этгээдээс багийн байрны засварт 5,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цалингийн зардалтай холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Г.Батмягмар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02/13 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,616,299.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,163.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасныг хэрэгжүүлээгүйгээс ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд 6,732.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон зөрчил илэрсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих нийт 1,531,220.9 мянган төгрөгийн 77 мэдээллээс 23,141.5 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудитаар урьдчилсан үйл ажиллагаа болон төлөвлөлтийн үе шатны ажлыг бүрэн хийсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 19,756.2 мянган төгрөгийн зөрчилд үр дүнгийн урамшуулал олгохдоо илүү тооцож олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүйгээс тэмцээн, уралдаанд дэмжлэг үзүүлсэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийн хэрэгжилтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны байдлаар шалгахад зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,070.6	1	1,070.6	100.0
Зөвлөмж	2	18,685.6	2	18,685.6	100.0
Нийт дүн	2	19,756.2	2	19,756.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,732.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

5.1.1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон байхад ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд урамшуулал олгосон	1	6,732.0					1	6,732.0				
Дүн	1	6,732.0	-	-	-	-	1	6,732.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 3 гүйлгээг мэдээлээгүй байна	1	23,141.5	-	-	-	-	1	23,141.5
Дүн	1	23,141.5	-	-	-	-	1	23,141.5